

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /МАЯГТ I/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлдэг. Өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

| | |
|--|--|
| Тайлагнах хугацаа | 2024 оны 1-р сарын 01 - 2024 оны 12-р сарын 31 |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | СҮҮ ХК, УБГД: 0002 9594 ҮЦК: 135-СҮҮ /Утас: 77(7-22)2 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын хөрөнгийн бирж |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, Үхрийн сүүний ферм, малын тэжээлийн урсгал тариалах |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | БДО Аудит ХХК |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 344.000.000 ширхэг |
| Жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрэхжаргал |

| | | |
|-----|--|---|
| 1 | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | Тайланг хавсаргав. |
| | Орлогын тайлан | Тайланг хавсаргав. |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | Тайланг хавсаргав. |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | Тайланг хавсаргав. |
| 1.1 | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт хараахан гараагүй байна. |
| 1.2 | Аудитын тодорхойлох захидал/тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгыг хүрээнд боловсруулсан байх/ | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт хараахан гараагүй байна. |

| | | |
|-----|--|--|
| 2 | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | |
| 2.1 | Үйл ажиллагааны үрдүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | Нийт ашгийн хувь: 29.9% Цэвэр ашгийн хувь: 3.3% Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 10.3% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 27.4% |
| 2.2 | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | Эргэлтийн харьцаа: 0.92 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 0.39 |
| 2.3 | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл | |
| 2.4 | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НББББичгийн дагуу бүртгэсэн. |
| 2.5 | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл. | Тайлант хугацаанд зээлийн бүх эргэн төлөлт/үд хугацаандаа хийгдсэн. |

| | |
|---|---|
| 3 | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусган/ |
|---|---|

| | | |
|---|----------------------------|---|
| 4 | Цалин урамшууллын мэдээлэл | Компанийн цалингийн сүлжээний дагуу олгогддог |
|---|----------------------------|---|

| | | |
|---|--|--|
| 5 | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл | Төлөөлөн удирдах зөвлөлтэй бөгөөд 12 гишүүнтэй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх, аудитын, Өрсдэлийн удирдлага, комплайнсын гэх 4 хороотой. |
|---|--|--|

| | | |
|----|---|--|
| 6 | Зах зээлийн үр дэлгэцийн мэдээлэл | Байхгүй |
| 7 | Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ | ЖАМБЯН: хувьцааны тоо 133103000 ГАНБААТАР: хувьцааны тоо 113730000 УЯНГАЛЯНХУА: хувьцааны тоо 72240000 хувьцаа эзэмшигчтэй. 11000 |
| 8 | Үнэт цаас гаргагчдын төсөл хэрэгжүүлэх зорилгээр нийтэд санал болгон хувьцаа гаргаач бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн зэрэгжилтийн явц болон таган төвлөрүүлсэн хэргийн зарцуулалтын тайлан мэдээлэл | байхгүй |
| 9 | Ногдол ашигчийн мэдээлэл | 2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгж хувьцаанд 10.6 төгрөг, нийт 3.6 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тарааж, 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг болгон олгох ТУЗ-н хурлыг товлосон. |
| 10 | Үнэт цаас гаргагчаас гайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажилын тайлангийн мэдээлэл | Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон эр цэргийн баярын өдрүүдээр хэрэглэгч болон сүү бэлтгэн нийлүүлэгчдээ баярлуулан социал контент болгон гаргаж, 1000 ээжүүдийн цугларах MOM 2.0 үйл ажиллагаа, 2024 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал, Аморе брэндийн нэрэмжит шатрын тэмцээн, сүү бэлтгэн нийлүүлэгчдээ алдаршуулах Дэлхийн сүүний өдөр зэрэг үйл ажиллагааг харилцагчидт ай хамтран зохион байгуулсан. Түүнчлэн TENUUN CUP 2024, FAMILY FESTIVAL 2024, Монголын Оюун ухааны академийн ой тогтоолын тэмцээн зэрэг үйл ажиллагааг ивээн тэтгэсэн. |

Мэдээлэл гаргачдын үзсэн мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б. Гантулга
 Албан тушаал: "СҮҮ" ХК-ийн Гүйцэтгэх захирал
 Гарын үсэг: 
 (Тамга тэмдэг) 
 УЛААНБААТАР ХОТ

Мэдээлэл бэлтгэж, зургуулсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:
 Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч Д. Дэлгэрэхжаргал
 Гарын үсэг: 



2025

"СУУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ





ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирц бүртгэх, /30 минут/
2. Хурлын ирц мэдээлэх, /1 минут/
3. Хурлыг нээлт, /5 минут/
4. Хэлэлцэх асуудал №1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал, /60-90 минут/,
 - Компанийн үйл ажиллагааны тайлан,
 - Компанийн санхүүгийн тайлан,
 - Хөндлөнгийн аудиторын 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт,
 - “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын 2024 оны үйл ажиллагааны тайлан,
 - Компанийн дотоод аудит, түүний тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт,
 - Гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын гүйцэтгэлийн шалгуур,
 - Компанийн засаглалын кодексын хэрэгжилт,
 - “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
5. Хэлэлцэх асуудал №2: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал, /5 минут/,
6. Хэлэлцэх асуудал №3: ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал, /10 минут/,
7. Хэлэлцэх асуудал №4: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал, /3 минут/,
8. Хэлэлцэх асуудал №5: “Сүү” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал, /5 минут/,
9. Хувьцаа эзэмшигчдээс асуулт, санал, хүсэлт хүлээн авах, /15 минут/,
10. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуулт, санал, хүсэлтэд хариулах, /10-15 минут/,
11. Хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал хураалт зохион байгуулах, /20 минут/,
12. Хурлын завсарлага /15-20 минут/
13. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, /5-10 минут/
14. Хурлыг хаах /5 минут/



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

**ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛ №1**



66 ЖИЛИЙН ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ИХ СҮҮГ БЭЛТГЭЛЭЭ

Сүүний чанар сайн, хэмжээ их байхын хэрээр Монгол Улсын өнцөг булан бүрд байгаа хэрэглэгч бүр эрүүл чанартай сүү, сүүн бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэх юм. Хамгийн сүүлийн 5 жил буюу цар тахлын эд үеэс эхлэн өнөөдрийг хүртэлх хугацаанд Сүү ХК-ийн татан төвлөрүүлж байгаа сүүний хэмжээ тогтмол нэмэгдэж байна. Энэ жилийн хувьд жилийн түүхэнд хамгийн их сүү бэлтгэн нийлүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн амжилттай байлаа. Түүнээс гадна өнгөрөгч 2023 онд сүү бэлтгэн нийлүүлэлтийг 22 хоршоо байгуулсан амжилттай байж 2024 онд 30 болгох зорилт тавьсан. Энэхүү зорилгоо 100% биелүүлээд байна. Сүү бэлтгэн нийлүүлэлтийн хоршоо нэмэгдсэнээр малчдаас гарах зардлыг бууруулж, орлогыг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйл болж байгаа юм.

ХУДАЛДАН АВАЛТЫН НИЙТ ХЭМЖЭЭ




БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСААС 64 ХЭЭЛТЭЙ ГУНЖИЙГ СҮҮ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧДЭДЭЭ НИЙЛҮҮЛЛЭЭ

Бүгд Найрамдах Франц улсаас орж ирсэн монбиллярд үүлдрийн 64 хээлтэй гунж 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсад ирсэн. Хүлээж авсан өдрөөс хойш эдгээр үхрүүд 14 хоног карентинлагдаж, бүрэн үзлэг шинжилгээнд хамрагдсаны дараа албан ёсоор малчид фермерүүддээ хүлээлгэн өгсөн бөгөөд цаашид энэхүү ажлыг тогтмолжуулж цэвэр үүлдрийн хээлтэй гунжийг оруулж ирж бэлтгэн нийлүүлэгчдэдээ нийлүүлж байх зорилт тавин ажиллаж байн



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАВ

Сүү ХК-ийн хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хамгийн гол орц бол сүү байдаг билээ. Нийт 2500 гаруй малчид фермерүүд болон 29 хоршоодын сүү бэлтгэн нийлүүлэгчдэдээ зориулан өвлийн өвс тэжээлийн туслалцаа үзүүлдэг. Өнгөрсөн жил 1500 тонн хивэг тараасан бол 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 800 тонн эрдэнэ шишийн дарштарааж байна. Ингэснээр малчдыг дэмжих эргээд чанартай сүү бэлтгүүлэн авах томоохон ажил гэж харж байгаа юм.



СҮҮ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Сүү ХК-ийн сүү бэлтгэн нийлүүлэгчид болон хоршоодын гишүүдэд зориулж улирал тутам сургалт зохион байгуулдаг. Тухайлбал Сүүний гарц нэмэгдүүлэх чиглэлээр, Антибиотикийн зохистой хэрэглээ, Тэжээл болон малын идэш тэжээлийн талаар гэх мэтчилэн үе шаттай сургалт зохион байгуулж, хоршоодод очиж практик зөвлөгөө өгч ажилладаг. 2024 оны хувьд томоохон онцлох сургалтууд зохион байгуулагдсан.



Тухайлбал:

БНХАУ-аас Well hope группийн тэжээлийн үйлдвэрийн мэргэжилтнүүдийг урьж, сургалт орсон.

Мөн БНХГУ-ын мэргэжилтэн Борис ирж, хоршоодод очиж зөвлөгөө өгч, бүх нийтийн сургалтыг EBRD-тай хамтарсан зөвлөх үйлчилгээний хүрээнд сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Жил бүр Нутаг академитай хамтран “Зохиомол хээлтүүлэг”-ийн чиглэлээр Зоо техникч бэлтгэх вакумжуулсан хоршоодын гишүүдээ сургалтад хамруулсан.

Мал эмнэлэгийн ерөнхий газартай хамтран “Антибиотик эмийн зохистой хэрэглээ” сургалтыг хоршоодын гишүүд дарга нарт зохион байгуулсан.



ОФФИСЫН ШИНЭ БАРИЛГЫН ТӨСӨЛ

1985 онд барилга болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж байх үед сүүний үйлдвэр одоогийн Сонгинохайрхан дүүрэгт шинээн үйлдвэр, оффисын барилгатаа орж байв. Өмч хувьчлалын салхинд сүүний үйлдвэрийн оффисын барилга, үйлдвэрийн барилгаасаа тусдаа хувьчлагдсан юм.

2024 онд тэмдэглэх томоохон үйл явдлын нэг нь өөрийн оффисын барилгаа эргэн авч, хамгийн сүүлийн үеийн шинэлэг байдлаар засварлаж, ажилчдын тав тухтай ажлаа хийх боломжтой тоног төхөөрөмж, амт чанартай, эрүүл хоолтой ресторан, фитнес тэйгээр үүд хаалгаа нээгээд байна.

Ажиллахад таатай оффист орсноор ая тухтай таатай орчин, нөхцөлийг цогцлоосон томоохон хөрөнгө оруулалт болсон гэж харж байгаа юм. Түүгээр барахгүй ажилтан нэг бүрийн эрүүл мэнд бидний хувьд үнэт зүйл билээ. Тиймээс оффисын барилга нь жижиг тоосонцрын хэмжээнд хүртэл сайтар шүүх агааржуулалтын системтэй гэдгээрээ онцлогтой юм.



МӨРӨӨДЛИЙН ЦЭЦЭРЛЭГ


Шинэхэн оффист ажилчид маань ая тухтай ажиллахын хажуугаар 2024-2025 оны хичээлийн шинэ жилээр Сүү ХК-ийн дэргэдэх "Мөрөөдлийн цэцэрлэг" үүд хаалгаа нээлээ. Нийт 120 хүүхдийн багтаамжтай тус цэцэрлэгт 3-5 насны хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж эхлээд байна.

Шим тэжээлтэй хоол, "Үдийн сүү" хөтөлбөр хэрэгжихээс гадна 24/7 цагийн дотоод хяналттай учир ажилчид маань санаа амар хүүхдүүдээ өглөө дагуулан ирж, орой тарахдаа хамтдаа тарах баяр хөөртэй хамтдаа байх аз жаргалтай мөчийг бид бэлэглэж байна.

РЕСТОРАН, КОФЕ ШОП

Манайд байгууллагын ажлын томоохон онцлог нь хоногийн 24 цагийн тасралтгүй системээр үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс үйлдвэрийн хамгийн гол цэг дээр ажиллаж байгаа ажилтан бүр 3 ээлжээр буюу уртасгасан цагийн хуваариар ажилладаг. Ээлжээр тэр тусмаа оройн цагаар ажиллаж байгаа хүмүүст эрүүл чанартай хоол хамгийн чухал.

Энэ ч утгаараа ажлын цайны газар гэдэг ойлголтыг бид халж өдөр хамгийн өндөр шим тэжээлтэй рестораны өдрийн хоол, өглөөний цай, десертээр үйлчилж байна. Түүнээс гадна ажилчид бүр-кофе шопоор хүссэн үедээ үйлчлүүлэх боломжтой юм.



SUU ФИТНЕСС



Suu фитнесээр хичээллэх давуу тал нь ажилтан бүр өөрийн ажлын байр, ажлын ачаалал зэргээс шалтгаалан өөр өөр зөвлөгөөг мэргэжлийн багшаас авч бэлтгэлээ хийх бүрэн боломжтой. Мэргэжлийн багшийн заавар зөвлөгөөнд хоол зүй, эрүүл амьдралын хэв маяг, дасгал хөдөлгөөний цогц систем зөвлөгөө тус тус хамаарна. Түүнээс гадна фитнес нь хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүд дээр бэлтгэл сургуулилт хийдгээрээ давуу талтай юм.



SUU 2.0 ТӨСӨЛ

Бид "Сүү 2.0" нэртэй томоохон төслийг шинээр эхлүүлээд тухайн ажил маань эд өрнөж байна. Энэ нь барилга, дэд бүтцийн хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлэх төсөл юм. Уг төсөл хэрэгжсэнээр дараа дараагийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулахад чиглэсэн дэд бүтэцтэй барилгууд баригдах юм.

Ингэснээр ирэх 10 жилийн хугацаанд "Сүү" ХК-ийн борлуулалтыг хэд дахин нэмэгдүүлэх боломж, нөгөө талдаа бүтээгдэхүүнээ экспортод гаргах бэлтгэл ажил хангах зорилго бүхий ач холбогдол өндөртэй томоохон төсөл юм.



ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ



Тарагны найрлага бэлтгэх автомат систем, тараг боловсруулах тоног төхөөрөмж, автомат СІР систем, ММС авдарлах роботын систем, амиакийн хөргөлтийн системийн шинэчлэл, удирдлагын автоматжуулалт, нам даралтын хийн хангамжийн шинэ эх үүсвэр гэх мэт нийт 13 төслийг амжилттай хэрэгжүүлэв.

АММИАКИЙН ХӨРГӨХ СИСТЕМ



Аммиакийн хөргөх системийн ууршуулагч конденсатор, ресивер, аммиакийн аюулгүй байдлыг хангах бүрэн автомат удирдлагын системийн шинэчлэлт хийгдэв.

СҮҮ ХК ХАС БАНК БОЛОН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХАМТЫН САНХҮҮЖИЛТЭЭР АВСАН 26 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ БҮРЭН ТӨЛЖ ДУУСГАЛАА



2019 оны 4-р сард Сүү ХК Хас банк болон Европын Сэргээн Босголтын Хөгжлийн банкт хамтын ажиллагаагаа эхлүүлэн 26 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг 5 жилийн хугацаатай авч, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зарцуулан шинэчилж, тус зээлийг 2024 оны 4-р сард буюу хугацаандаа бүрэн төлж дуусгалаа. Ингэснээр Сүү ХК нь санхүүгийн сахилга баттай, эрүүл санхүүг цогцлоосон байгууллага гэдгээ баталлаа.

**СҮҮ ХК НЬ МУИС-
ИЙН ШИНЖЛЭХ
УХААНЫ СУРГУУЛЬ,
ШУТИС-ИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СУРГУУЛЬ,
ХААИС-ИУДТАЙ
ТУС БҮР ХАМТЫН
АЖИЛЛАГААГАА
БЭХЖҮҮЛЭН
АЖИЛЛАЖ БАЙНА**



Энэхүү ажлын хүрээнд оюутнуудад тэтгэлэг олгох, танилцах болон мэргэжлийн цалинтай дадлага хийж, практик дээр ур чадвараа бататгаж, ажлын байраар хангагдах зэрэг олон боломжууд нээлттэй болох боломжтой боллоо.

Талуудын хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулийн оюутнууд Сүү компанид танилцах болон мэргэжлийн цалинтай дадлага хийж, практик дээр ур чадвараа бататгаж, ажлын байраар хангагдах зэрэг олон боломжууд нээлттэй юм.

Үндэсний үйлдвэрлэлийн салбартаа чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмрээ оруулах, МОНГОЛ УЛСЫН СТРАТЕГИЙН ХҮНС болох сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт залгамж халааг үргэлжлүүлэх зорилготой энэхүү хамтын ажиллагаанууд нь Сүү ХК-ийн нийгмийн хариуцлагын тэргүүн зорилтуудын нэг юм.

"СҮҮ" ХК-ИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

СҮҮ ХК НЬ НИЙТ



38,000,000₮

төгрөгийн тэтгэлэг зарласан юм



Сүү ХК нь Монгол улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн, коллежийн өдрийн ангийн 2-4 дүгээр шатлалд суралцаж буй Хүнсний үйлдвэрлэлийн технологи, Үйлдвэрийн автоматжуулалт, Хөргөлтийн систем, Мехатроник, Цахилгааны Инженер зэрэг техник, технологийн чиглэлийн оюутнуудад бүтэн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгож, цалинтай дадлага, ажлын байрны урилга гардуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тус тэтгэлэгт хөтөлбөрт нийт их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн чиглэлийн 60 гаруй оюутан залуус хамрагдсанаас ярилцлагын шатанд 22 оюутан шалгарсан. Үүнээс 2 шат буюу ярилцлагын шатанд нийт 8 оюутан тэнцэж 100% тэтгэлэгийн эрхээ гардан авлаа. Сүү ХК-ийн хувьд энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг нийгмийн хариуцлагын хүрээнд нарийн мэргэжлийн инженер, техник, хүнсний үйлдвэрлэлийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулан, оюутан залууст тус мэргэжлийн чиглэлийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулах нь тухайн тэтгэлэгт хөтөлбөрийн гол зорилгын нэг юм.




СУРГАЛТЫН
ТӨЛБӨР **100%**
ОЛГОНО

Монгол улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн 2-5-р дамжаанд суралцаж буй **Хүнсний технологи, Хүнс үйлдвэрлэл, Инженер, Техникийн чиглэлийн 8 ОЮУТАНД бүтэн жилийн 100%-ийн сургалтын төлбөр буюу 30,000,000 сая төгрөгийн тэтгэлэг**, мөн 14 оюутанд ажлын байрны урилга, цалинтай дадлага хийх урилгыг тус тус гардууллаа.



УЛСЫН БИОЛОГИЙН ОЛИМПИАД

Сүү ХК нь МУИС-ийн Биологийн тэнхимтэй байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Улсын биологийн XXXIV-ээр олимпиадыг ивээн тэтгэн ажилласан. Тус олимпиадад амжилт гаргасан оюутнуудад цалинтай дадлага хийх болон ажлын байраар бүрэн хангах боломжийг бий болгон ажилласан.



“СҮҮН БАЯР”–2024 АРГА ХЭМЖЭЭ

Сүү ХК-ийн хувьд Улаанбаатар хотын 350 км-ийн радиуст байрлах 6 аймгийн газар нутгаас сүү бэлтгэдэг. Тодруулбал Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Хэнтий зэрэг аймгууд багтдаг. Эдгээр дундаас хамгийн их сүүгээ Төв аймгийн газар нутгаас бэлтгэн нийлүүлдэг. Жил бүр Төв аймгийн ЗДТГ-аас уламжлалболгон “Төвтүмний Сүүнбаяр”-аатэмдэглэн өнгөрүүлдэг. Сүү ХК-ийн энэ арга хэмжээнд жил бүр тогтмол оролцдог бөгөөд энэ жилийн хувьд Төв аймгийн Баянчандмань суманд амжилттай оролцож, бүтээгдэхүүний дээжээ амтлуулан ажиллалаа.



“АМОРЕ” ӨСВӨРИЙН ШАТРЫН ТЭМЦЭЭН



2024 онд СүүХК-ийн нэрэмжит өсвөрийн шатрын тэмцээнийг 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Анх зохион байгуулагдаж байх үеэсээ эхлэн Монголын хамгийн өндөр шагналын сантай гэдгээрээ тус спортоор хичээллэгчид болон шатрын спортынхны анхаарлыг татаж байсан тус

тэмцээнийг зорин ирэх хүүхдүүдийн тоо нэмэгдсээр байна. Энэ жил гэхэд нийт 600 гаруй өсвөрийн шатарчид өрсөлдлөө.

Нийт шагналын сан 35,000,000 ₮

“АМОРЕ” ФЕСТИВАЛ

Сүү ХК-ийн шилдэг брэнд бүтээгдэхүүн болох АМОРЕ -ийн нэрэмжит фестиваль 2016 оноос хойш 8 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж байна. Өмнө нь бид бүхэн Улаанбаатар хотын хэрэглэгчдэдээ зориулан 1000 зайрмагийн баяр нэртэйгээр зохион байгуулж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд орон нутгийн хэрэглэгчдэдээ зориулан зохион байгуулж байна. Тодруулбал 2023 онд бид Дархан-Уул, Дорнод зэрэг аймгийн хүүхэд залуучууддаа зориулан фестивалиа амжилттай зохион байгуулсан. Энэ жилийн хувьд Дорноговь, Өвөрхангай, Увс гэсэн маршрутаар энэ зуны хамгийн хит фестивалийг өргөн бүрэлдэхүүнээр зохион байгуулсан билээ. Энэ уламжлал жил бүр уламжлал болон хэрэгжиж чадсанаар хүүхэд, залуучуудын дунд хамгийн хүсэн хүлээсэн фестиваль, арга хэмжээ болоод байна.



“БАЙРТАЙ СҮҮ” ХОНЖВОРТ ХӨТӨЛБӨР

Жил бүрийн босгон дээр Сүү ХК нь үнэнч хэрэглэгчдэдээ зориулан идэвхжүүлэлт хөтөлбөр зарладаг билээ. Өнгөрсөн онд “**МАШИНТАЙ ХЭРЭГЛЭГЧ**” нэртэйгээр хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн бол энэ жилийн хувьд MILK болон ШИМТ брэндийн сүүгээ хэрэглэгдэг хэрэглэгчдийнхээ дунд “Байртай сүү” хонжворт хөтөлбөрийг зарласан.

Энэхүү хөтөлбөр нь нийт 6 тохирол явагдах бөгөөд энэ онд эхний 3 дугаараас нийт 24 супер азтан тодроод байна. Үргэлжлэн энэхүү хөтөлбөр 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүртэл үргэлжилж, 2 өрөө байрыг гардуулан өгсөн.

Итгэл даасан чанартай бүтээгдэхүүнийг минь сонгон хэрэглэгч бүхэндээ баярлалаа.



СУПЕР АЗТАН 2 ӨРӨӨ БАЙР



“ХҮНСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР” СҮҮ ХК

Монгол Улсын ууган үйлдвэр Сүү ХК нь 1958 онд нийслэлийн хүн амыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж зорилгоор 30 тонн сүү боловсруулах хүчин чадалтайгаар анх байгуулагдаж байсан түүхтэй. Эдүгээ бид 700 гаруй эжилтэн, албан хаагчтай хонгт 130-200 тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтайгаар 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн 4,200 штг хүрч зах зээлд нийлүүлж байна.



Орчин үеийн сүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр махчдыг хоршоонуулах хөтөлбөр хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар 31 сүү бэлтгэлийн хоршоо тогтвортой үйл ажиллагаагаа ханган ажиллаж байна. Мөн бид сүү бэлтгэл нэгдсэн системийг Улаанбаатар хот орчмын 350 км-ийн радиуст байрлах 6 аймгууд болж Төв, Дархан, Сэлэнгэ, Орхон, Хэнтий аймгуудын нийт 30 гаруй чиглэлийн 2,500 гаруй сүү бэлтгэн нийлүүлэгч, малчид фермерүүдээс жилийн 4-улирал тасралтгүй сүүгээ татаж авч байна.

Уламжлал ирсэн сүүн соёлыг орчин үеийн хэрэглээнд нийцүүлэн түгээх эрхэм зорилгын доор хичээн ажиллаж, дахин маналайлаа бататган ХҮНСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР-ээр шалгарлаа.



“ENTREPRENEUR - 2024” МӨНГӨН МЕРКУРИ ЦОМ

Бизнесийн салбарын нэр хүнд, үнэ цэнийг тодорхойлж ирсэн Монгол Улсын оны онцлох аж ахуйн нэгжийг шалгаруулдаг “Entrepreneur 2024” Меркури цом гардуулах ёслол хүндэтгэлийн 27 дэх удаагийн арга хэмжээнд “Сүү” ХК оны ШИЛДЭГ АЖ АХУЙ НЭГЖ-ээр шалгарч, МӨНГӨН МЕРКУРИ гардан авлаа.

“АМОРЕ” БРЭНД “АРД ТҮМНИЙ ХҮНС” ӨРГӨМЖЛӨЛӨӨР ШАГНАГДЛАА.

Монгол Улсын ууган үйлдвэр Сүү ХК-ийн “АМОРЕ” брэнд 2013 оноос эхлэн хэрэглэгч түмэндээ Итали технологийн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг 13 дахь жилдээ хүргэж байгаа билээ. Монголын хүнсний холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ард түмний хүнс: 2025” өргөмжлөлөөр шагнагдлаа.

13 жил тасралтгүй хэрэглэгчдэд хүрч буй “АМОРЕ” брэнд нь орц найрлага, түүхий эд зэргээрээ шилдэг байхаас гадна, хэрэглэгчдэдээ зориулж олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулдагаараа онцлогтой.





ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ

Монгол Улсын Ууган Үйлдвэр Сүү ХК “**ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ**”-ээр тодорч ЧАНСАА-гаа дахин бататгалаа.

Сүү ХК-ийн үнэ цэн болсон 29 хөршоо, 2500 гаруй малчин фермерүүд, Сүүн гэр бүл, 13,000 гаруй хувьцаа эзэмшигч, Монгол Улсын өнцөг булан бүрд байгаа эрхэм хэрэглэгч та бүхний хамтын үр дүн билээ.

Бид 2022 оны үзүүлэлтээр 82-р байранд орж байсан бол 2023 онд 12 байр урагшилж 70-р байранд шалгарлаа.

БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

СҮҮ
Milk

Малчны хөтнөөс
таны гэрл

Өмбөн
сүү

Миний
Монголын
сүү

СҮҮ

Шилт
сүү

SUPER

High

САЙХАН СҮҮ

ТАРАГ
Yogurt

Ахиад уумаар
амт

Элгэн
тараг

ПРОБИОТИК
ТАРАГ

Шилт

BIG
FIT

Амтлаг
• тараг •

Bofit Profit
Hifit

ЦОЦГИЙТЭН
ТАРАГ

ЗАЙРМАГ
Icecream

Хайр ундарсаар
Мөрөөдлийн амт

Amore

Мөрөөдлийн...

MILK
SHAKE

FROZEN
YOGURT

БУСАД
Others

Эрүүл органик

ЦОЦГИЙН
ТОС

Чээлтэй
аарц

Хархуй
Аарц

Аарц

Миний Монголын
Зөөхий



SACCO
system
Supporting food culture & life

3 ТӨРЛИЙН АШИГТАЙ БАКТЕРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛСЭН

Сүү ХК нь Италийн Sacco systems ХХК-тай "ОНЦГОЙ ЭРХИЙН ГЭРЭЭ" байгуулан хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд Сүү ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлтийн дарга Д.Ганбаатар болон Sacco systems ХХК-ийн бизнес хариуцсан захирал Juliane Gagel нар тус гэрээг үзэглэсэн юм.

Энэхүү гэрээ нь зөвхөн 2 байгууллагын хоорондын биш Монгол хүн бүрийн эрүүл мэндэд зориулсан эрүүл мэндийн гэрээ юм. Тодруулбал Сүү ХК Sacco systems ХХК-аас онцгой эрхтэйгээр хүний биед хамгийн өндөр ашигтай, эрүүл мэндийн пробиотикуудыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж байгаа юм.

Coit
Игол
боловсруулах
системийг
дэмжинэ

Hail
Амьсгалын
замын үйл
ажиллагааг
дэмжинэ

Pait
Зүрх
судасны үйл
ажиллагааг
дэмжинэ

Дархлааны системийг дэмжинэ



3 FIT

Италийн Sacco systems XXX-тай хийсэн ОНЦГОЙ ЭРХИЙН ГЭРЭЭ-ний хүрээнд савлагаа тус бүрдээ 15 тэрбум ашигтай бактери агуулсан HiFit, ProFit, GoFit зэрэг бүтээгдэхүүнүүд нь 2024 оны 05 дугаар сараас эхлэг хэрэглэгчийн гарт хүрч, зах зээлд амжилттай танигдаад байна. Гэдсээрээ гэрэлтєе уриатай тус 3 төрлийн бүтээгдэхүүн нь тус бүр өөр өөрийн гэсэн эрүүл мэндийн чиглэлээр нөлөө үзүүлж байна.

Борлуулалтын төлөвлөлтийг **90.3%** биелүүлэв.



Кранчтай ЭЛГЭН ТАРАГ

Уламжлалт саванд нь бүрсэн элгэн тараг нэр төрлөө нэмж Кофе болон овьёос, Хулууны үр болон хатаасан самар, бяслагийн амттай кранчаар баяжуулсан олон төрлөөр зах зээлд амжилттай танигдсан.



АМТЛАГ хөлдөөсөн тараг

Хэрэглэгчдэд хэдийнээ танигдсан "Амтлаг" бифидо ашигтай бактераар баялаг хөлдөөсөн тараг төрлөө нэмж КИВИ, ГҮЗЭЭЛЗГЭНЭ-тэй төрлөө нэмлээ.



AMORE зайрмаг

Итали технологиор үйлдвэрлэсэн нэг удаагийн хэрэглээнд нийцүүлэн 75гр-аар савласан Гүзээлгэнэтэй, Иристэй, Шоколадтай гэсэн 3 төрлийн амттай зайрмаг.

Борлуулалтын төлөвлөлтийн биелэлт
192%
807.621 ширхэг
зах зээлд нэвтрүүлэв

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Сүү хувьцаат компани нь Монгол Улсын ууган үйлдвэрийн хувьд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй бизнес эрхэлж, өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа, алсын хараа, нийгмийн хариуцлагын бодлогоо чиглүүлэн ажиллаж байна.

Бидний хувьд "Монгол сүүгээр дэлхийг ундаалах" эрхэм зорилгынхоо хүрээнд эх орондоо эрүүл хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, тэгш хүртээмжтэй тогтмол ажлын байрыг тасралтгүй бий болгох замаар тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Бидний зорьж хэрэгжүүлж буй энэхүү ажлууд нийгэмд эерэг өөрчлөлт авчрахад томоохон нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Сүүн соёлыг түгээх их үйлсийг өвөртлөн буй бидний үйл ажиллагааг дэмжин, хамтран ажилладаг эрхэм хэрэглэгч, харилцагч та бүхэнд талархал илэрхийлье.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ, ХЭМНЭЛТ, ҮР АШИГ

Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд үйлдвэрлэлийн техник, технологийн шат дараалсан шинэчлэлт хийгдсэнээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглаж байгаа цэвэрлэгээний химийн бодис ашиглалт 30%, ус болон уур цахилгаан зарцуулалт 15-25% тус тус буурсан.

Технологийн шугамын цэвэрлэгээний СІР системийг цогцоор нь шинэчилж бүрэн автомат систем ашигласнаар хаягдал усны хэмжээг багасгах дахин ашиглах боломж бий болсон.

Хэмнэлтийн мэдээлэл



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Сүү ХК нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль орчинд үзүүлэх хог хаягдлын үр нөлөөг багасгаж, дахин ашиглаж, боловсруулах хэрэглээний хэв маягийг бүрдүүлэх зорилгоор хог хаягдлаа ангилан ялгаж ашигладаг.

"СҮҮ" ХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг нийт 5 ангилдаг.

1. Цаасан хог хаягдал
2. Хуванцар хог хаягдал
3. Төмрийн хаягдал
4. Химийн хог хаягдал
5. Ахуйн хог хаягдал

30-35 тн

цаасан хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт тушааж байна.

7166.3 кг

хуванцар хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт тушаасан байна.





ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

УРЬДЧИЛСАН ЗААВАРЧИЛГАА

2022 ОН | 315 АЖИЛТАН
Дундаж үнэлгээ 93.4%

2023 ОН | 403 АЖИЛТАН
Дундаж үнэлгээ 93.6%

2024 ОН | 589 АЖИЛТАН
Дундаж үнэлгээ 90.2%

ДАВТАН ЗААВАРЧИЛГАА

2022 ОН | 29 АЖИЛТАН

2023 ОН | 22 АЖИЛТАН

2024 ОН | 33 АЖИЛТАН

АЖЛЫН БАЙРНЫ ХАБЭА-Н ҮЗЛЭГ ХЯНАЛТ

63 Засаж залруулсан
нийт үл тохирлын тоо

АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Эрдэнэтийн салбар үйлдвэрийн 19
ажлын байранд "Хэлт Сэфти анд Фрий
Воркилэйсэс" ХХК-иар хийлгэсэн.

ХАБЭА-Н СУРГАЛТУУД

2024 ОНД НИЙТ

403 АЖИЛТАН

Сэрээт өргөгчийн
операторын эрх олгох
сургалт **17**
АЖИЛТАН

Цацрагийн аюулгүй
байдлын сургалт **12**
АЖИЛТАН

Гамшгаас хамгаалах
анхан шатны сургалт **175**
АЖИЛТАН

Нийт ажилтны
ХАБЭА-н сургалт **118**
АЖИЛТАН

Ажил олгогчийн
ХАБЭА-н сургалт **14**
АЖИЛТАН

Галын дохиололын
системийн тоног
төхөөрөмжийн
ажиллагаа хяналт
сургалт **10**
АЖИЛТАН


Аргон гагнуурын
сургалт **5**
АЖИЛТАН

БИЕЛЭЛТ

100%

ХҮНИЙ НӨӨЦ

Сүү ХК нь тэгш хүртээмжтэй, олон талт оролцоог хангасан "Хүн төвт" бодлогын хүрээнд ажилтнуудынхаа чанартай амьдралын баталгаа болон сайн сайхан байдлыг дэмжин ажиллаж байна. Нийгэмдээ хувь нэмэр, үнэ цэн бүтээхийн тулд ажилтан бүр оролцоотой, хөгжих сэтгэлгээтэй, ёс зүйтэй байхыг эрмэлздэг.



737
НИЙТ АЖИЛТАН

8
УДИРДАХ ТҮВШНИЙ
ЭМЭГТЭЙ АЖИЛТАН



40.2%
ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

9
УДИРДАХ ТҮВШНИЙ
ЭРЭГТЭЙ АЖИЛТАН



59.8%
ЭРЭГТЭЙ АЖИЛТАН

ДУНДАЖ
АЖИЛЛАСАН
ЖИЛ **5.6**

ДУНДАЖ
АЖИЛЛАСАН
ЖИЛ **3.5**

30
ТЭТГЭВРИЙН
НАСНЫ
АЖИЛТНЫ ТОО

18
ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
АЖИЛТНЫ ТОО

114
2024 ОНД
ШИНЭЭР БИЙ
БОЛСОН ОРОН
ТОО

20
ГЭРЭЭТ
АЖИЛТНЫ
ТОО

30
ХҮҮХЭД АСРАХ
ЧӨЛӨӨТЭЙ БАЙГАА
АЖИЛТНЫ ТОО

ЁС ЗҮЙН ХОРОО

Ёс зүйн манлайлал ба соёлыг түгээх, бикнесийн ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчдлийн гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Дотоод болон гадаадад мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн олон талт ур чадварыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Гадны эксперт, зөвлөхүүдтэй хамтарч ажиллах, туршлага солилцох бүрэн боломжтой.

Англи хэлний ур чадварыг бүх ажилтнууддаа хүртээмжтэй сайжруулахын тулд мэргэжлийн сургалтын төвтэй хамтран ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ АЖИЛЛУУЛАХ БОДЛОГО

Жил бүр тогтвортой, өндөр гүйцэтгэлтэй ажилтнуудын орон байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор орон сууц, хашаа байшингийн урьдчилгаанд нэг ажилтанд дунджаар 15,000,000-30,000,000 төгрөгийн урамшуулал олгодог.



КАРЬЕР, ХӨГЖЛИЙН ХУВЬД

Удирдлагын багийн бүрэлдэхүүн ажилтнуудынхаа карьер, хөгжил, өсөндөвших боломжийг дэмжин, чиглүүлэн ажилладаг.

Мэргэжлийн ур чадвараа тасралтгүй сайжруулж, компани дотроо 3-5 удаа албан тушаал дэвшин ажилласан туршлага олон байгааг дуулгахад таатай байна.



**“АЖИЛТАН БҮР ЭЗЭН”
ХУВЬЦААЖУУЛАХ
ХӨТӨЛБӨР**


СүүХК-ийнхувьдсүүнгэрбүлийнгишүүн бүр томоохон үнэ цэнийг өгч байдаг. Түүний нэгэн адил ажилтан бүр эзний ёсоор хандаж, үнэ цэнийг хүртдэг соёлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанидаа өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж, идэвх санаачилгатай, тууштай 5 ба түүнээс дээш жил ажилласан ажилчдадаа Сүү ХК-ийн хувьцаа эзэмших эрхийг олгодог.




УЯН ХАТАН, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

Сүү ХК-ийн ажилтан бүр тэгш хүртээмжтэй, хүний эрхийг дээдэлсэн уян хатан ажлын байрыг дэмжин ажилладаг. Хийж хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:

ЦАГИЙН УЯН ХАТАН
БОДЛОГО



УЛИРЛЫН
УРАМШУУЛАЛ



АХМАДУУД БОЛОН
ОЮУТНУУДЫГ ДЭМЖСЭН
ЦАГИЙН, ГЭРЭЭТ АЖЛЫН
БАЙР



КОМПАНИЙН ДОТООД ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүү компанийн хувьд нээлттэй соёл, баг хамт олны дунд эерэг уур амьсгалыг тасралтгүй дэмжих зорилгоор олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Онцгойлон сонирхлын клубууд дээр төвлөрч ажилладаг. Спортын клубуудын хувьд Компанийн шигшээ багийн бүрэлдэхүүн байхаас гадна шинэ гишүүддээ анхан шатны техникээс эхлэн зааж, сардаа нэг удаа мэргэжлийн багш дасгалжуулагчаас заавар, зөвлөгөө авдаг. Түүнчлэн жил бүр SUU CUP спортын тэмцээнийг зохион байгуулдаг ба энэ жилийн хувьд SUU CUP -2024 оны үйл ажиллагаа нь 10 баг, 8 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



SUU FC Хал бөмбөгийн клуб



Анхан шатны сонирхогчдоос эхлэн үндэсний дээд, дигийн тамирчин, гүйцэтгэх удирдлагыг багтаасан нийт 38 гишүүний бүрэлдэхүүнтэй. Халбөмбөгийн клуб нь зуны улиралд гадна талбайд, бусад үед спорт зааланд 7 хоног бүр хичээллэдэг.

Жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.



BLUE BULL Сагсан бөмбөгийн клуб



Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй багаас бүрдсэн 44 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 7 хоног бүр спорт зааланд хичээллэдэг.

Жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.



SUU Гэр бөмбөгийн клуб

Тус клубын хувьд эрэгтэй, эмэгтэй гишүүдээс бүрдсэн 39 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 7 хоног бүр спорт зааланд хичээллэдэг.

Жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.

E SPORT CLUB

Тус клубын хувьд улирла бүр И-спорт тич ааварг а шалгаруулах дотоодын тэмцээн зохион байгуулагд.

Тоглодог төрлүүдийн хувьд Pubg mobile, CS:GO, Mobile Legends, PES, FIFA гэх мэт.

Жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.



SUU DARTS CLUB

Бэр бүр гишүүдийн чансаа тогтоох тэмцээн зохион байгуулдаг ба нийт 43 гишүүний бүрэлдэхүүнтэй клуб юм.



SUU HIKING CLUB

Явган амьлын клубыг Сүүн гэр бүлийн гишүүн, мэргэжлийн уулчин удирдан зохион байгуулдаг.

Сард нэг удаа амралт цэн үдрөөр явган амьл зохион байгуулж, амьлт нуурын гол идэвхтэй хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжин амилладаг байна.



СҮҮН ГЭР БҮЛ


Зуны фестиваль

Жил бүр компанийн хэлтээнд "Зуны фестиваль" зохион байгуулж, нямдаг амьлт, баярт мөчөө хуваалцан, тандагдлаж өнгөрүүлдэг.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Зах зээлд эрүүл мэндэд тустай инноваци шингэсэн бүтээгдэхүүнүүдийг амжилттай гаргаж, үйлдвэрлэл болон борлуулалтын хүчин чадлаа нэмэгдүүлсний үр дүнд 2024 оны байдлаар Сүү ХК-ийн борлуулалтын орлого **192.4** тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулбал **▲30%**-ийн өсөлтийг үзүүлсэн байна.



2024 оны байдлаар Сүү ХК-ийн **цэвэр ашиг** өмнөх оны мөн үетэй харьцуулахад **▲26%** өсөж **17.8 тэрбум** төгрөгт хүрлээ.



2024 оны байдлаар Сүү ХК-ийн **нийт ашиг** өмнөх оны мөн үетэй харьцуулахад **▲28%** өсөж **57.4 тэрбум** төгрөгт хүрлээ.


Компани 2024 онд томоохон тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, үйлдвэрлэлийн бүтээмж болон хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг зардлыг бууруулснаар нийт ашиг нэмэгдлээ.



САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

| | Хэмжих нэгж ('000'000) | Аудитлагдсан нэгтгэсэн тайлан 2023 | Аудитлагдсан нэгтгэсэн тайлан 2024 | Өсөлт % |
|---|---------------------------|--|--|-------------|
| САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН | | | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | Сая.₮ | 53,026 | 49,788 | ↓-6% |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | Сая.₮ | 68,204 | 107,358 | ↑57% |
| Нийт Хөрөнгө | Сая.₮ | 121,230 | 157,146 | ↑30% |
| Өр Төлбөр | Сая.₮ | 73,016 | 96,769 | ↑33% |
| Эздийн өмч | Сая.₮ | 48,214 | 60,377 | ↑25% |
| Нийт өр төлбөр ба Эздийн өмч | Сая.₮ | 121,230 | 157,146 | ↑29% |
| ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН | | | | |
| Борлуулалтын орлого (цэвэр) | Сая.₮ | 147,793 | 192,399 | ↑30% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | Сая.₮ | 102,610 | 134,850 | ↑31% |
| Нийт ашиг (алдагдал) | Сая.₮ | 44,902 | 57,446 | ↑28% |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | Сая.₮ | 17,455 | 21,095 | ↑21% |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | Сая.₮ | 14,218 | 17,824 | ↑25% |

Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/





МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Хөндлөнгийн аудиторын 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт

БДО АУДИТ ХХК

ХАРААТ БУС

ГЭРЭЭТ АЖЛЫН БАГ

Эрсдлийн Удирдлагын
партнер **Д. АЛТАНСҮХ**
/МНБ, ТМЗ, FCGMA/

Гэрээт ажлын
партнер **Л. БАЯРЦОГЗОЛ**
/МНБ, ТМЗ/

Чанарын хяналтын
партнер **KHURSHID ALAM**
/МНБ/

Аудитын менежер **Н. БАЙГАЛМАА**
/МНБ, ТМЗ/

Ахлах аудитор **С. ҮҮРИЙНЦОЛМОН**

Туслах аудитор **ТУСЛАХ АУДИТОР**
(4)

АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн
тайлангийн дүн,
ангилал, толилуулга,
тодруулга

=

СТ-ИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайлангийн
үзэл баримтлалын дагуу
тайлагнасан байвал
зохих дүн, ангилал,
толилуулга, тодруулга

ЭЕРЭГ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Сүү ХХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНАЛ ДҮГНЭЛТ

Сүү ХХ (Компанн) -ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдлын тайлан
- Энэ өдөрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өөрийн хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудыг болон
- Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын мэдээлэл.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНАЛ ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ыг дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЕЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЕЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелгүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

БУСАД МЭДЭЭЛЭЛ

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь гүйцэтгэх удирдлагын зүгээс хөрөнгө оруулагчид болон нээлттэй зах зээлд зориулан бэлтгэсэн жилийн тайлан, мөн зээлдүүлэгчдэд зориулан бэлтгэсэн бусад тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг аач үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.



АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Биологийн хөрөнгийн анхны болон дараа үеийн хэмжилт

СТОУС-ын дагуу компанийн биологийн хөрөнгийг анх болон тайлант жил бүрийн эцэст борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжиж тайлагнахыг шаарддаг. Энэхүү бодит үнэ цэний тооцоолол нь удирдлагыг томоохон тооцоолол ба таамаглал хийхийг шаарддаг ба бодит үнэ цэний хэмжилтийн нөлөөгөөр нь санхүүгийн тайлангийн, алдагдалд шууд нөлөөлнө.

Бараа материалын хэмжилт

СТОУС-ын дагуу компанийн бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэний аль багаар хэмжиж бүртгэхийг шаарддаг. Энэхүү цэвэр боломжит үнэ цэний тооцоолол нь удирдлагыг бараа материалын иж бүрдэл болох тооцоолсон зардал болон борлуулахад бэлэн болгох тооцоолсон зардал дээр үндэслэн барааны цэвэр боломжит үнэ цэнийг тооцож, барааны өртөгтэй харьцуулан аль багаар хэмжиж толилуулахыг шаарддаг.

Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого хүлээн зөвшөөрөлт

Орлого нь компанийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашигладаг чухал хэмжүүр юм. Орлого хүлээн зөвшөөрөх үйл явдал нь ямагт компанийн бодитоор бий болгосон дүнгээс өндөр дүнгээр орлого хүлээн зөвшөөрч, тайлагнасан байх эрсдэлийг бий болгож байдаг. Борлуулалтын гүйлгээ хийгдэж, бараа бүтээгдэхүүн үйлчлүүлэгчид хүргэгдэж, үүний үр дүнд компанийн эдийн засгийн бүх эрсдэл худалдан авагчид шилжсэн үед орлогыг хүлээн зөвшөөрдөг. Барааг дэлгүүрт хүргэж, худалдан авагчид шилжүүлснээр, эсвэл барааг худалдан авагч барааны үнийг төлж, худалдан авагчийн байршилд барааг хүргэсэн цэгт орлого хүлээн зөвшөөрдөг. Үнэн зөв орлого хүлээн зөвшөөрөлтийг аудитын гол асуудал гэж бид дүгнэсэн.

Хүүгийн хувь хэмжээний дэмжлэгтэй Засгийн газраас олгосон зээлийн анхны болон дараа үеийн хэмжилт

Компани нь “Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас хариуцсан төлөх зээлийн хүүгийн дэмжлэгтэй зээлийн гэрээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Хас банктэй хамтарч байгуулсан байна. Энэхүү хүүгийн дэмжлэгтэй зээлийн гэрээний хүрээнд компани зээлийн бүртгэлийн анхны хэмжилтийг бодит үнэ цэнээр нь хэмжиж бүртгэх болон засгийн газрын буцалтгүй тусламжийн хойшлогдсон орлогыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэхийг холбогдох СТОУС -аар шаарддаг.



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНД УДИРДЛАГА БА ЗАСАГЛАХ УДИРДЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД АУДИТОРЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Мөн бид:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөөлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид эдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл хариу арга хэмжээ зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

| | Тэм | 2024 он мян.төг | 2023 он мян.төг |
|--|-----|--------------------|--------------------|
| Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого | 5 | 192,399,371 | 147,793,353 |
| Борлуулалтын өртөг | 6 | (134,849,708) | (102,610,200) |
| Үнэ цэний бүүралтын гарз | 17 | (103,550) | (281,104) |
| Нийт ашиг | | 57,446,113 | 44,902,049 |
| Бусад орлого | 7 | 2,816,224 | 1,389,874 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 8 | (11,308,065) | (7,995,703) |
| Борлуулалт ба маркетингийн зардал | 9 | (21,118,439) | (13,134,863) |
| Биологийн хөрөнгийн бодит үнэ цэний бүүралтын гарз | 25 | (1,541,632) | (2,209,084) |
| Бусад зардал | 11 | (157,488) | (360,713) |
| Үндсэн үйл ажиллагааны ашиг | | 26,136,713 | 22,591,560 |
| Санхүүгийн орлого | 12 | 47,518 | 16,917 |
| Санхүүгийн зардал | 12 | (5,089,488) | (5,153,727) |
| Татварын өмнөх ашиг | | 21,094,743 | 17,454,750 |
| Орлогын албан татварын зардал | 13 | (3,270,812) | (3,236,532) |
| Тайлант жилийн ашиг | | 17,823,931 | 14,218,218 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | | | |
| Суурь болон хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг - төгрөг | 14 | 52 | 41 |

Тайлант жилд
Нэгж хувьцааны ашиг

52

төгрөг байна

Санхүүгийн байдлын тайлан

| | Тэм | 2024 оны 12 сарын 31 мян.төг | 2023 оны 12 сарын 31 мян.төг |
|--|-----|------------------------------------|------------------------------------|
| Хөрөнгө | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Бараа материал | 16 | 32,781,243 | 22,238,723 |
| Биологийн хөрөнгө | 25 | 413,427 | 599,576 |
| Худалдааны болон бусад авлага | 17 | 7,518,420 | 5,008,054 |
| Холбоотой талуудаас авах зээлийн авлага | 18 | 318,792 | 434,393 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 19 | 7,089,259 | 9,158,439 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 20 | 1,618,714 | 15,572,256 |
| | | 49,739,855 | 53,011,441 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | 21 | 48,300 | 14,700 |
| | | 49,788,155 | 53,026,141 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж | 22 | 94,355,488 | 54,942,814 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 23 | 489,680 | - |
| Хөрөнгө ашиглах эрх | 24 | 1,764,562 | 741,489 |
| Биологийн хөрөнгө | 25 | 1,132,303 | 863,525 |
| Биет бус хөрөнгө | 26 | 158,086 | 146,610 |
| Урьдчилж төлсөн төлбөр – Эргэлтийн бус | 19 | 9,457,578 | 11,509,909 |
| | | 107,357,697 | 68,204,347 |
| Нийт эргэлтийн бус хөрөнгө | | 107,357,697 | 68,204,347 |
| Нийт хөрөнгө | | 157,145,852 | 121,230,488 |

| | Тэм | 2024 оны 12 сарын 31 мян.төг | 2023 оны 12 сарын 31 мян.төг |
|--|-----|------------------------------------|------------------------------------|
| Өр төлбөр | | | |
| Богино хугацаат өр төлбөр | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 28 | 35,435,931 | 12,066,384 |
| Зээл болон өр төлбөр | 29 | 26,142,950 | 26,143,912 |
| Түрээсийн өр төлбөр | 24 | 207,451 | 366,543 |
| Гэрээний өр төлбөр | 5 | 72,126 | 33,569 |
| Орлогын татварын өглөг | 13 | 242,527 | 1,376,163 |
| | | 62,100,985 | 39,986,571 |
| Нийт богино хугацаат өр төлбөр | | 62,100,985 | 39,986,571 |
| Урт хугацаат өр төлбөр | | | |
| Зээл болон өр төлбөр | 29 | 23,987,898 | 24,874,730 |
| Түрээсийн өр төлбөр | 24 | 1,386,725 | 171,770 |
| Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламжийн орлого | 27 | 8,891,609 | 7,735,779 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 13 | 401,487 | 246,740 |
| | | 34,667,719 | 33,029,019 |
| Нийт урт хугацаат өр төлбөр | | 34,667,719 | 33,029,019 |
| Нийт өр төлбөр | | 96,768,704 | 73,015,590 |
| Өмч | | | |
| Хувьцаат капитал | 30 | 34,400 | 34,400 |
| Нэмж төлөгдсөн капитал | 30 | 60,102 | 60,102 |
| Халаасны хувьцаа | 30 | (87) | (87) |
| Хүримтлагдсан ашиг | | 60,282,733 | 48,120,483 |
| | | 60,377,148 | 48,214,898 |
| Нийт өмч | | 60,377,148 | 48,214,898 |
| Нийт өр төлбөр ба өмч | | 157,145,852 | 121,230,488 |



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

**“Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөл болон Төлөөлөн удирдах
зөвлөлийн дэргэдэх хороодын
2024 оны үйл ажиллагааны тайлан**

“СҮҮ” ХК- ИЙН ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 04 сарын 21-ний өдрийн “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг томилсон бөгөөд нийт 12 гишүүнийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг байнгын, тогтвортой, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон компанийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд Компанийн засаглалын кодексын дагуу 2024 оны 04 сарын 16-ны өдрийн №08 тоот Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоолоор “Нэр дэвшүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байлгаж, ТУЗ-ийн гишүүдийн олонхыг хараат бус болгохоор зорилт тавин ажиллаж байна.


Түүнчлэн ТУЗ нь компанийг зүй зохистой удирдан сайн засаглалын практикийг хэвшүүлж стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьсан.

Компанийн үйл ажиллагааны хүрээнд Suu 2.0 төслийн хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах буюу Макс Өргөө ХХК-тай үйлдвэрийн барилга байгууламж өргөтгөх зориглоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон.

Үүгээр зогсохгүй 2024 оны 04 сарын 24-ний өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хуралд тооллогын комиссын гишүүнээр Нексиа Глобал Монголиа Аудит ХХК-ийн төлөөллийг оролцуулж, хөндлөнгийн хяналтыг хийлгэлээ.

ТУЗ-ийн хурал: Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцож, тухай бүр асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд нийт 16 тогтоол баталсан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод



| № Овог нэр | Албан тушаал | Ажиллах албан тушаал |
|---|---------------------------|----------------------|
| НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО | | |
| 1. Б.Батзориг | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны дарга |
| 2. Д.Ганбаатар | ТУЗ-ийн гишүүн | Хорооны гишүүн |
| 3. Н.Цэрэндорж | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны гишүүн |
| АУДИТЫН ХОРОО | | |
| 1. Н.Цэрэндорж | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны дарга |
| 2. Д.Тунгалаг | ТУЗ-ийн гишүүн | Хорооны гишүүн |
| 3. Г.Баяр | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны гишүүн |
| ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО | | |
| 1. Д.Давааням | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны дарга |
| 2. Д.Цэрэнжигмэд | ТУЗ-ийн гишүүн | Хорооны гишүүн |
| 3. Г.Баяр | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны гишүүн |
| ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, КОМПЛАЙНСЫН ХОРОО | | |
| 1. Н.Цэрэндорж | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны дарга |
| 2. С.Отгонжаргал | ТУЗ-ийн гишүүн | Хорооны гишүүн |
| 3. Д.Давааням | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Хорооны гишүүн |

Нэр дэвшүүлэх хорооноос компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх боломжтой этгээдийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, уулзалт ярилцлага хийх, нөөцийн бүртгэлд бүртгэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон, хяналт тавин ажиллаж байна.

Цалин урамшууллын хорооноос компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлан, тогтмол судалгаа хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавихаас гадна олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулан ажиллаж байна.

Сүү ХК-ийн Төлөөлөн Удирдан Зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн №10 тогтоолоор шинээр байгуулагдаж улмаар компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянах болон комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.

КОМПАНИЙН ДОТООД АУДИТ, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,

2022.03.15-ний өдрийн №22/02/01 тоот Сүү ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт, 2022.07.06-ний өдрийн №14 тоот Сүү ХК-ийн ТУЗ-ийн тогтоолын дагуу Дотоод аудитын үйл ажиллагааг “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г үндэслэн “Макс импекс” ХХК-ийн Дотоод аудитын хэлтэс хэрэгжүүлдэг.

ДОТООД АУДИТЫН ЧИГ ҮҮРЭГ

Сүү ХК-ийн Дотоод аудитын зааврын дагуу дор дурдсан чиглэлтэй байна. Үүнд:

1. Компанийн засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;
2. Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх, сайжруулах;
3. Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах;
4. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх.

БҮТЭЦ:

Дарга 1

Ахлах аудитор

Аудитор

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН





МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, ноёд хатагтай нар аа

Монгол орны шим тэжээлээр баялаг хөрсөнд ургасан эмийн ургамлыг идэш тэжээлдээ хэрэглэдэг малын хишиг, ариун цагаан сүүнд тулгуурлан “Сүү” ХК нь 70 гаруй нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, зөвхөн нийслэл төдийгүй орон нутгийн иргэдийг эрүүл, амт чанартай хүнсээр хангахын төлөө өдөр бүр чармайн ажиллаж байна.

Манай компанийн гол зорилго нь хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлж, өдөр тутмын хэрэгцээт хүнсээр ханган, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд оршдог билээ. Үүний хүрээнд бид 66 жилийн түүхэн дэх хамгийн их сүү болох 28.9 сая литр сүүг бэлтгэсэн амжилттайгаар онцгойрч байна.

2024 онд бид үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, дэд бүтцээ сайжруулах зорилтын хүрээнд бодит хөрөнгө оруулалтуудыг амжилттай хэрэгжүүлж, дараах томоохон төслүүдийг хэрэгжүүллээ. Үүнд:

- Аммиакийн хөргөлтийн системийн шинэчлэл
- Таргийн найрлага бэлтгэх автомат систем
- Тараг боловсруулах тоног төхөөрөмж
- Автомат СІР систем
- ММС авдарлах роботын систем
- Нам даралтын хийн хангамжийн шинэ эх үүсвэр
- Шинэ оффисын барилга
- Мөрөөдлийн цэцэрлэгийн төсөл гэх мэт нийт 13 төсөл амжилттай хэрэгжүүлсэн байна.

Мөн цаашид үйлдвэрлэл, дэд бүтцийн хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлэх зорилготой “Сүү 2.0” төслийг эхлүүлээд байгаа бөгөөд уг төсөл нь бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг шинэ шатанд гаргах чухал төсөл болоод байна.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хүрээнд бид:

- Амтлаг хөлдөөсөн тараг
 - Super сүү
 - Amore зайрмаг
 - 3 Fit бүтээгдэхүүн
- гэх мэт нийт 9 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

Ийнхүү 2024 оны жилийн эцэст бид 192.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 16 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан амжилтаар онцгой жилээ үдэж байна.



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Хэлэлцэх асуудал №2: **Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт** **оруулах тухай асуудал**

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

"СҮҮ" ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

| № | Одоогийн заалт | Нэмэлт өөрчлөлт орсны дараа |
|----|--|---|
| 1 | - | Дүрмийн дугаарлалт, хэлбэрийг засварлав. |
| 2 | 1.2.Компанийн оноосон албан ёсны нэр: | 1.2.Компанийн оноосон албан ёсны нэр, <u>регистрийн дугаар, бүртгэлийн дугаар</u> |
| 3 | - | <u>2.7.Компани нь компанийн тухай хуульд заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд бие даасан хуулийн этгээдийн статусаар компанийн үндсэн зорилго, зорилт, стратегийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.</u> |
| 4 | 3.3.Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана. | 3.3.Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана. |
| 5 | 4.1.Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 429,589,000 ширхэг энгийн хувьцаа байна. | 4.1.Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй <u>344,000,000</u> ширхэг энгийн хувьцаа байна. |
| 6 | Тав. Компанийн удирдлага, Хувьцаа эзэмшигчдийн хурал | Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| 7 | 5.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. | 5.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. <u>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг эрх бүхий байгууллагын баталсан журамд заасан хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хурал зохион байгуулах хэлбэрийг ТУЗ-н хурлаар сонгон, шийдвэрлэнэ.</u> |
| 8 | 5.6 компанийн тухай хуулийн 33.8-д заасны дагуу компани нь эргүүлэн худалдан авсан хувьцааг дахин гаргаж болно. | 2.8 компанийн тухай <u>хуульд заасны дагуу</u> компани нь эргүүлэн худалдан авсан хувьцааг дахин гаргаж болно. |
| 9 | 5.10.Хувьцаа эзэмшигч өөрийгөө төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ. | 5.10. Хувьцаа эзэмшигч өөрийгөө төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа <u>хувьцаа эзэмшигчдийн хурал</u> эхлэхээс өмнө мэдэгдэнэ. |
| 10 | 5.12. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. | 5.12. Хувьцаа эзэмшигч хурлаар хэлэлцэх <u>асуудал болон</u> гарах шийдвэрийн төсөлд бичгээр <u>эсхүл цахим хэлбэрээр</u> санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. |
| 11 | 5.14.хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор | 5.14 хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг компанийн тухай <u>хуульд заасны дагуу</u> хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурна. |

| | | |
|----|---|---|
| | хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурна. | |
| 12 | 5.16.эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна. | 5.16.эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд Компанийн тухай <u>хуульд заасан</u> эчнээ санал хураалтын шийдвэрт тусгахаар заасан зүйлийг тусгасан байна. |
| 13 | 5.19. Компани цахимээр санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. | 5.19. Компани цахимээр санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, <u>бүртгэл болон</u> санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. |
| 14 | 6.2.3.компанийг татан буулгах үед компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх; | 6.2.3.компанийг татан буулгах үед компанийн тухай <u>хуульд</u> заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх; |
| 15 | 6.2.6 ¹ компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар нэмж гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшигчдийн саналаар шийдвэрлэж болно. | 6.2.6 ¹ компанийн тухай <u>хуульд</u> зааснаар нэмж гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшигчдийн саналаар шийдвэрлэж болно. |
| 16 | 7.9.компанийн тухай хуулийн 33.3-т заасны дагуу дээрх шийдвэрийг ТУЗ гаргана. | 7.9.компанийн тухай <u>хуульд заасан зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг ТУЗ тогтооно.</u> |
| 17 | Найм.төлөөлөн удирдах зөвлөл | Найм.төлөөлөн удирдах зөвлөл, <u>түүний дэргэдэх хороод</u> |
| 18 | - | 8 дугаар бүлэгт заасан ТУЗ-н дарга, ТУЗ -ийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагын эрхийг 9 дүгээр бүлэг болгон өөрчлөв. |
| 19 | - | 8.5 ТУЗ-ийн ердийн гишүүн нь компанийн тухай хуульд заасан шаардлагаас гадна нэмэлтээр дараахь шаардлагыг хангасан хувь хүн байна. Үүнд: 8.5.1 Мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан, бизнесийн удирдлагын дадлага туршлагатай; 8.5.2 Компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш байх; 8.5.3 Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх; |

| | | |
|----|---|---|
| | | 8.5.4 Өмнө нь дампуурсан компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаагүй; 8.5.5 Өмнө нь аль нэг компанийн ТУЗ-ийн гишүүн байх үедээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон бол түүнээс хойш 3-аас доошгүй жил өнгөрсөн байх; |
| 20 | 8.6 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна. | 8.6. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь компанийн тухай хуульд заасан шаардлагаас гадна нэмэлтээр дараахь шаардлагыг хангасан хувь хүн байна. |
| 21 | 8.6.5.компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш; | 8.6.5. Компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш; |
| 22 | 8.8.ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 8.5-8.7-д заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрэмд заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. | 8.8.ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэхүү дүрэм болон компанийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг ТУЗ-н гишүүнд нэр дэвшүүлнэ. ТУЗ-н гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрэмд заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. |
| 23 | - | 8.14. ТУЗ-н компанийн засаглалын кодексийг мөрдөн, хэрэгжилтийг хангаж, холбогдох ажлыг зохион байгуулна. |
| 24 | 8.15.13.Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох; | 8.15.13.Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, удирдлагыг томилох, охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг эдлэх. |
| 25 | - | 8.15.21.ТУЗ-н дарга, ТУЗ-н дэргэдэх хороод гишүүдийг томилох, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлох үйл ажиллагааны журмыг батлах; |
| 26 | - | 8.15.22.Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа бөгөөд компанийг нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд тус компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг батлах; |
| 27 | - | 8.15.23.Компанийн Гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнуудын эрх мэдлийн матриц, баримт бичгийг батлах; |
| 28 | - | 8.15.24.Энгийн хувьцаа худалдан авах, олгох эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион гаргах шийдвэр гаргах, холбогдох журмыг батлах; |

| | | |
|----|--|---|
| 29 | - | 8.15.25.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох; |
| 30 | 8.25 ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. | 8.11 ТУЗ-ийн гишүүд нь урамшуулал авах бөгөөд түүний хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. |
| 31 | 8.26. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой нэр дэвшүүлэх, аудитийн болон цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. | 8.26. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой нэр дэвшүүлэх, аудитийн болон цалин урамшууллын, эрсдэлийн удирдлага, комплайнсын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. |
| 32 | 8.27.ТУЗ-ийн аудитийн хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү,бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна. | 8.27.ТУЗ-ийн дэргэдэх хорооны дарга нь хараат бус гишүүн байна. |
| 33 | - | 8.28-8.30 дугаар зүйлийн "ТУЗ-н дэргэдэх" гэж өөрчлөө. |
| 34 | 8.28.ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй. Үүнд: 8.28.1.компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах үр чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх; 8.28.2.жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ д ажиллаж байсан эсэх; 8.28.3.компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх; 8.28.4.компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх; | 8.8 ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй. Үүнд: 8.8.1 Компанийн ТУЗ-ийн холбогдох журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах үр чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх; 8.8.2 Жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ д ажиллаж байсан эсэх; 8.8.3 Компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх; |
| 35 | 8.31 дүгээр зүйлийг "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхыг хориглох нөхцөл" | 8.7 дугаар зүйл буюу "Дор дурдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно. Үүнд:" |
| 36 | - | 8.31.ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлага, комплайнсын хороо нь дараах чиг үүрэгтэй. Үүнд: 8.31.1.эрсдэлийн удирдлагыг бий болгох замаар компанийн засаглалыг сайжруулах; |

| | | |
|----|---|--|
| | | <u>8.31.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх;</u> <u>8.31.3.байгууллагын комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах;</u> <u>8.31.4.зөрчлийн талаар мэдээлэх "шүгэл үлээх" ажиллагааг хэрэгжүүлэх;</u> |
| 37 | Ес. Компанийн эрх бүхий албан тушаалтан, Тэдгээрийн; хариуцлага | Ес. Компанийн эрх бүхий албан тушаалтан, Тэдгээрийн эрх, хариуцлага |
| 38 | - | Найм дугаар бүлэгт заасан ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагын эрхийг 9 дүгээр бүлэгт шилжүүлэв. |
| 39 | 9.15.гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. | 9.15.гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр <u>төлөөлөх ба дор дурдсан ерөнхий эрх хэмжээний хүрээнд ажиллаж ТУЗ-тай байгуулах гэрээнд тусгайлан нэмэлт эрх хэмжээг тогтооно.</u> |
| 40 | 9.15.7. Компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно. | 9.15.7. Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох, <u>гэрээ байгуулах эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно;</u> |
| 41 | - | 10.15 Компани "ахмадын сан"-тай байх бөгөөд мөнгөн хөрөнгийн хэмжээ нь тухайн жилийн цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцүү байна. |
| 42 | 11.1.ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. | 11.1.ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ <u>гаргах бөгөөд хагас жилээр ногдол ашиг тараах шийдвэр гаргаж болно.</u> |
| 43 | 11.4.ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр эсхүл мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. | 11.4.ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр эсхүл <u>цахим хэлбэрээр мэдэгдэнэ.</u> Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. |
| 44 | 12.1.компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитийн хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ. | 12.1.компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, <u>дотоод аудитаар дамжуулан хэрэгжүүлнэ.</u> |
| 45 | - | <u>12.2.дотоод аудитыг багаар хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ-өөс баталсан компанийн бүтцээр орон тоог тодорхойлно.</u> |

| | | |
|----|---|--|
| 46 | - | <u>12.3.дотоод аудитыг ТУЗ-өөс томилох бөгөөд ТУЗ-с баталсан дотоод аудитын заавар болон аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн, удирдамжийн дагуу ажиллана.</u> |
| 47 | - | <u>12.4.дотоод аудит нь компанийн бүхий л үйл ажиллагааны түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагааг явуулах бөгөөд дараах чиглэлтэй байна. Үүнд:</u> <u>12.4.1.Засаглалын тогтолцоо,</u> <u>12.4.2.Дотоод хяналтын тогтолцоо,</u> <u>12.4.3.Эрсдэлийн удирдлагын тогтолцоо,</u> <u>12.4.4.Аудитын чиг үүрэгт хамаарах бусад тогтолцоо,</u> <u>12.4.5.Бизнесийн үндсэн үйл ажиллагаа,</u> <u>12.4.6.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа,</u> <u>12.4.7.Албаны үйл ажиллагаа.</u> |
| 48 | 12.5.компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ. | 12.5.Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын <u>нэгж, ажилтан</u> хэрэгжүүлнэ. |
| 49 | 12.6.дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна. | 12.6. Дотоод хяналтын <u>нэгж, ажилтан</u> нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-с баталсан дотоод хяналтын <u>зааврын дагуу</u> үйл ажиллагаагаа явуулна. |
| 50 | Дотоод хяналтын алба | 12.7-12.10 заалтуудад "Нэгж, ажилтан" нэршлийг өөрчлөн тусгав. |



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Хэлэлцэх асуудал №3: **ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн** **бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож,** **ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар** **сонгох тухай асуудал**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Ердийн гишүүнд



Д.ГАНБААТАР
Макс группийн эрх зориулагч
Боловсрол: 1998 он, Сохиолч Политтехникийн дээд сургууль, Барилгын инженер, Бакалавр



Д.ЦЭРЭНЖИГМЭД
Макс группийн Ерөнхий захирал
Боловсрол: 2000 он, Оттоктэнгэр их сургууль, Эрх зүйн, Бакалавр



Д.ЖАМБЯН
ТУЗ-ийн гишүүн
Боловсрол: 2002 он, Монгол улсын их сургууль, Олон улсын харилцааны сургууль, Бакалавр



Д.УЯНГАЛЯНХУА
Макслэйн ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Боловсрол: 2002 он, Олон улсын Эдийн засгийн дээд сургууль, Бакалавр
2012 он, Монгол улсын их сургууль, Олон улсын харилцааны сургууль, Олон улсын харилцаа, Магистр



Б.ТҮВШИНТӨГС
ТУЗ-ийн ердийн гишүүн
Боловсрол: 1985 он, Монгол улсын их сургууль, Биологийн
1989 он, МУШУА-ийн ЕБСБХ,
1991 он, Монгол улсын их сургууль, Аспирантур



Д.ТУНГАЛАГ
Макс группийн Санхүү харуусан захирал
Боловсрол: 1994 он, Монгол улсын их сургууль, Эдийн засагч, Бакалавр
2012-2013 Hull International business school, USA, Магистр



С.СҮХБОЛД
Макс группийн Худалдаа, аялал жуулчлалын бизнес харуусан захирал
Боловсрол: 201 он, АНУ, Lindenwood University, Marketing, Бакалавр



Б.ГАНТУЛГА
Сүү ХК-ийн гүйцэтгэх захирал
Боловсрол: 2003 он, Г.Б.Плехановын нээгэмжит ОУУ-ийн эдийн засгийн академ, Эдийн засагч, Бакалавр

Хараат бус гишүүнд



Б.АЛТАНГЭРЭЛ
Цэцэг хүү ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Боловсрол: 2000 он, Цагдаагийн академ, Эрх зүйн, Бакалавр
2006 он, Цагдаагийн академ, Хууль зүйн ухааны магистр
2015 он, Хууль сахиулагчийн их сургууль, Хууль зүйн ухааны доктор, Эрдэмтэн профессор



Г.БАЯР
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Боловсрол: 2001 он, ХЕНТУ, Ливинг колледж, Сертификат
2007 он, БНХАУ, Харилцаа холбоо, олон улсын аялал жуулчлал, эрхэнд бусдын менежмент, Бакалавр



Б.БАТЗОРИГ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Боловсрол: 2003 он, Монгол улсын их сургууль, Олон улсын харилцааны сургууль, ОУ-ийн эдийн засгийн харилцаа, Бакалавр
2007 он, Нидерландын Ханзэ Их сургууль, Бизнесийн удирдлага, Магистр



Д.ДАВААНЯМ
Мөнх ногоон тал ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Боловсрол: 1999 он, Монгол улсын их сургууль, ОН зүйн, Биологийн факультет, Бакалавр
2002 он, Биологийн ухааны магистр



Г.ОЮУНБОЛД
Блюксэйс сепаратив УЦК-ийн Гүйцэтгэх захирал
Боловсрол: 2002 он, Монгол улсын их сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйн, Бакалавр
2015 он, Хүнмүүслэлийн Ухааны Их Сургууль, Англи хэлний орчуулагч, Бакалавр



Т.ТҮВШИНСАЙХАН
Summit achievement consulting ХХК болон Heritage event ХХК-ийн 100% хувьцаа эзэмшигч
Боловсрол: Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Эрхэнд буудал, Зоогийн газрын менежмент, Бакалавр
2013 он, Монгол улсын их сургууль, Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлага, Магистр



Н.УЛААНХҮҮ
Интрик ассет менежмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Боловсрол: 2005 он, Монгол улсын их сургууль, Эдийн засгийн сургууль, Эдийн засагч, Бакалавр



Н.ЦЭРЭНДОРЖ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Боловсрол: 1980 он, Монгол улсын их сургууль, Олон улсын харилцааны сургууль, Магистр
2004 он, Удирдлагын академ, Бизнесийн удирдлага, Бакалавр





МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Хэлэлцэх асуудал №4: **ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын** **хэмжээг тогтоох тухай асуудал**

**ТУЗ-ИЙН ЦАЛИН,
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**






МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Хэлэлцэх асуудал №5:

**“Сүү” ХК-ийн 2024 оны эхний хагас
жилийн ногдол ашиг тараалтын тайлан
болон 2024 оны сүүлийн хагас жилийн
цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар
Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх
тухай асуудал,**

Нэгж хувьцаанд ногдох ашиг /₮/




2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан

Сүү ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 08 сарын 16-ны өдрийн №11 тоот "Ногдол ашиг хуваарилах тухай" тогтоолоор компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10.6 төгрөг буюу нийт 3,649,854,602 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолын дагуу 2024.12.31-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгав.

Ногдол ашиг тараалтын мөнгөн дүн /Тэрбум ₮/



2024 оны сүүлийн хагас жилд ногдол ашиг тараах тухай шийдвэр

Сүү ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 02 сарын 17-ны өдрийн №04 тоот "Ногдол ашиг хуваарилах тухай" тогтоолоор компанийн 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3.43 төгрөг буюу нийт 1,176,943,298.51 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн дагуу 2025.05.30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгахаар шийдвэрлэсэн.



МОНГОЛ УЛСЫН
УУГАН
ҮЙЛДВЭР

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**